



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цэнхэр сумын ИТХ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

**Аудитын код: АРА-2022/128/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Архангай аймаг  
2022 он

Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын тэргүүлэх аудитор: Т.Байгалмаа  
Утас: 70333141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Нэргүйбаатар  
Утас: 70332680 Цахим хаяг: Nerguibaatar@audit.gov.mn

Ахлах аудитор: Х.Алтанчимэг  
Утас: 90060105 Цахим хаяг: Altanchimegkh@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1.Аудитын санал дүгнэлт .....	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	7
3. Аудитын тайлан.....	8
3.1 Ерөнхий зүйл.....	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	9
3.4 Материаллаг байдал .....	9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	9
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	11
3.8 Аудитын гол асуудал .....	11
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	11
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	11
<b>3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....</b>	<b>12</b>
3.12 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12
4. Аудитын илрүүлэлт .....	13
4.1 Залруулсан алдаа.....	13
4.2 Төлбөрийн акт.....	13
4.3 Зөвлөмж .....	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	14

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар

## 1.Аудитын санал дүгнэлт

 <b>АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР</b> 65130 Цэцэрлэг, Архангай аймаг Утас/Факс:976-70333141 И-мэйл: arkhangai@audit.gov.mn	<p>ЦЭНХЭР СУМЫН ИТХ-ЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА С.БАДАМХАНД ТАНАА</p>
<p>2022.02.02 № 34 танай _____ -ны № _____ -т</p>	
<p><b>АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ</b></p> <p><b>Хязгаарлалттай дүгнэлт</b></p> <p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цэнхэр сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.</p> <p>Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Цэнхэр сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.</p> <p><b>Дүгнэлтийн үндэслэл</b></p> <p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгуулагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.</p> <p>Цэнхэр сумын ИТХ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар бараа үйлчилгээний бусад зардлаас 3.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн, тэтгэвэр тогтоолгоогүй байхад, тэтгэмж олгосон, Төрийн захиргааны албан тушаалын сул орон тоонд сонгон шалгаруулалт явуулах саналыг Төрийн албан салбар зөвлөлд хүргүүлээгүй, түүнд олгох цалин хөлс, нэмэгдлүүдийг хуучин хэвээр олгосон зэрэг зөрчил илэрсэн.</p> <p>Эдгээр зөрчил нь Төрийн албаны тухай хуулийн 27.2, 60.1, “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-ын 1.1, 5.3, 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43-р тогтоолын 1.4 дэх заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.</p> <p><b>Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага</b></p> <p>Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.</p>	

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,824,270.00	826,700.00
35	БАРАА МАТЕРИАЛ	1,824,270.00	826,700.00
351	Түүхий эд материал	97,800.00	267,700.00
35110	Тусгай зориулалттай материал	97,800.00	267,700.00
354	Хангамжийн материал	1,726,470.00	559,000.00
35410	Бичиг хэргийн материал	250,800.00	329,000.00
35420	Аж ахуйн материал	230,000.00	230,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	23,679,881.55	24,535,771.65
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	23,679,881.55	24,535,771.65
392	Биет хөрөнгө	23,679,881.55	23,585,771.65
39203	Авто-тээврийн хэрэгсэл	30,256,433.00	30,256,433.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(6,807,697.38)	(9,833,340.66)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	3,905,364.00	7,572,364.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(3,826,701.66)	(4,520,368.32)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,344,109.00	1,344,109.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(1,191,625.41)	(1,233,425.37)
393	Биет бус хөрөнгө	-	950,000.00
39301	Програм хангамж	-	950,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	25,504,151.55	25,362,471.65
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	25,504,151.55	25,362,471.65
51	Засгийн газрын хувь оролцоо	25,504,151.55	25,362,471.65
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	5,646,000.00	5,646,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	19,795,408.24	19,653,728.34
51210	Өмнөх үеийн үр дүн	19,795,408.24	19,795,408.24
51220	Тайлант үеийн үр дүн	-	(141,679.90)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	62,743.31	62,743.31
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	25,504,151.55	25,362,471.65

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	94,933,000.00	87,397,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	650,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	650,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	650,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	650,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	94,933,000.00	86,747,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	5,380,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	5,380,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	94,933,000.00	81,367,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	94,933,000.00	81,367,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	99,115,427.88	87,538,979.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	99,115,427.88	87,538,979.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	69,811,999.59	83,280,233.14
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	50,768,071.71	54,864,422.99

210101	Үндсэн цалин	50,768,071.71	54,864,422.99
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,869,400.00	6,639,030.25
210201	Тэтгэврийн даатгал	4,834,000.00	4,941,897.69
210202	Тэтгэмжийн даатгал	508,800.00	550,988.28
210203	ҮОМШӨ-ний даатгал	407,100.00	440,790.59
210204	Ажилгүйдлийн даатгал	101,800.00	52,641.94
210205	Эрүүл мэндийн даатгал	1,017,700.00	652,711.75
2104	Хангамж, бараа материалын зардал	7,637,630.00	11,823,670.00
210401	Бичиг хэрэг	1,206,760.00	671,800.00
210402	Тээвэр, шатахуун	5,406,370.00	9,903,070.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	600,000.00	600,000.00
210404	Ном, хэвлэл	160,000.00	156,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	264,500.00	492,800.00
2107	Томилолт, зочны зардал	200,000.00	500,000.00
210702	Дотоод албан томилолт	200,000.00	500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	440,000.00	4,220,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	60,000.00	3,780,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	280,000.00	280,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	60,000.00	60,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	100,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,896,897.88	5,233,109.90
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	932,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	540,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	3,896,897.88	3,761,109.90
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,303,428.29	4,258,746.76
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	577,128.29	4,258,746.76
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	577,128.29	4,258,746.76
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(4,182,427.88)</u>	<u>(141,679.90)</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(4,182,427.88)</u>	<u>(141,679.90)</u>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,646,000.00	62,743.31	19,795,408.24	25,504,151.55
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	5,646,000.00	62,743.31	19,795,408.24	25,504,151.55
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,646,000.00	62,743.31	19,795,408.24	25,504,151.55
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-141,679.90	-141,679.90
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	5,646,000.00	62,743.31	19,653,728.34	25,362,471.65

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Цэнхэр сумын ИТХ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>94,933,000.00</u>	<u>86,747,300.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	94,933,000.00	86,747,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	5,380,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	5,380,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	94,933,000.00	81,367,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	94,933,000.00	81,367,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>94,433,000.00</u>	<u>82,780,300.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	94,433,000.00	82,780,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	65,129,571.71	78,521,553.24
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	50,768,071.71	54,864,422.99
210101	Үндсэн цалин	50,768,071.71	54,864,422.99
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,869,400.00	6,639,030.25
210201	Тэтгэврийн даатгал	4,834,000.00	4,941,897.69
210202	Тэтгэмжийн даатгал	508,800.00	550,988.28
210203	ҮОМШӨ-ний даатгал	407,100.00	440,790.59
210204	Ажилгүйдлийн даатгал	101,800.00	52,641.94
210205	Эрүүл мэндийн даатгал	1,017,700.00	652,711.75
2104	Хангамж, бараа материалын зардал	6,563,100.00	3,633,700.00
210401	Бичиг хэрэг	750,000.00	725,000.00
210402	Тээвэр, шатахуун	4,653,100.00	1,895,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	600,000.00	600,000.00
210404	Ном, хэвлэл	160,000.00	156,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	400,000.00	257,700.00
2107	Томиллолт, зочны зардал	389,000.00	500,000.00
210702	Дотоод албан томиллолт	389,000.00	500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	540,000.00	7,280,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	160,000.00	6,840,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	280,000.00	280,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	60,000.00	60,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	100,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	5,604,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	5,064,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	540,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,303,428.29	4,258,746.76
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	577,128.29	4,258,746.76
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	577,128.29	4,258,746.76
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>500,000.00</u>	<u>3,967,000.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	3,967,000.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	81,367,300.0	77,108,553.2	4,258,746.8	94.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	81,367,300.0	77,108,553.2	4,258,746.8	94.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	81,367,300.0	77,108,553.2	4,258,746.8	94.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	57,904,200.0	54,864,423.0	3,039,777.0	94.8
210101	Үндсэн цалин	57,904,200.0	54,864,423.0	3,039,777.0	94.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,817,100.0	6,639,030.3	1,178,069.8	84.9
210201	Тэтгэврийн даатгал	5,500,900.0	4,941,897.7	559,002.3	89.8
210202	Тэтгэмжийн даатгал	579,100.0	550,988.3	28,111.7	95.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	463,200.0	440,790.6	22,409.4	95.2
210204	Ажилгүйдлийн даатгал	115,800.0	52,641.9	63,158.1	45.5
210205	Эрүүл мэндийн даатгал	1,158,100.0	652,711.8	505,388.3	56.4
2104	Хангамж, бараа материалын зардал	3,633,700.0	3,633,700.0	-	100.0
210401	Бичиг хэрэг	725,000.0	725,000.0	-	100.0
210402	Тээвэр, шатахуун	1,895,000.0	1,895,000.0	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	600,000.0	600,000.0	-	100.0
210404	Ном, хэвлэл	156,000.0	156,000.0	-	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	257,700.0	257,700.0	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	500,000.0	500,000.0	-	100.0
210702	Дотоод албан томилолт	500,000.0	500,000.0	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,480,000.0	2,440,000.0	40,000.0	98.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,000,000.0	2,000,000.0	-	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	280,000.0	280,000.0	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	60,000.0	60,000.0	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	100,000.0	100,000.0	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,032,300.0	9,031,400.0	900.0	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,032,300.0	9,031,400.0	900.0	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	81,367,300.0	77,108,553.2	4,258,746.8	94.8
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	81,367,300.0	77,108,553.2	4,258,746.8	94.8
132001	Орон нутгийн төсвөөс	81,367,300.0	77,108,553.2	4,258,746.8	94.8

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,380,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,380,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,380,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,840,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,840,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	540,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	540,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,380,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,380,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,380,000.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Цэнхэр сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад нягтлан бодох бүртгэлийн анхан шатны нотлох баримтыг бүрэн бүрдүүлэх, шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Х.Алтанчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Цэнхэр сумын ИТХ нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн 01 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Цэнхэр сумын ИТХ нь Нутгийн өөрөө удирдах байгууллагын шийдвэр, Улсын Их Хурлаас гаргасан хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, түүнтэй нийцүүлэн гаргасан нутгийн захиргааны шийдвэрүүдэд хяналт тавьж биелэлтийг хангуулахад байгууллагын зорилготой үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын хяналтын багийн чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цэнхэр сумын ИТХ нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвөөс сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 81.3 сая төгрөгөөс 1%-иар буюу 0.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 %-иар буюу буюу 0.6 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 0.2 сая төгрөгөөр буурсан байна. Оны эхний үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан данс нь бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /сая.төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Хувь
Бараа материал	1.8	0.8	(1.0)	(0.6)
Үндсэн хөрөнгө	23.7	24.5	0.8	0.0
<b>Нийт хөрөнгө</b>	<b>25.5</b>	<b>25.4</b>	(0.2)	(0.0)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	25.5	25.4	(0.1)	(0.0)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>25.5</b>	<b>25.4</b>	(0.1)	(0.0)

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

*-Бараа материал эхний үлдэгдлээс 0.6 хувиар буурсан байна.*

Бараа материалын данс нь 1.8 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 10.0 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд 11.0 сая төгрөгийн бараа материалыг зарцуулан оны эцэст 0.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

*-Үндсэн хөрөнгө эхний үлдэгдлээс 0.2 хувиар буурсан байна.*

Үндсэн хөрөнгө данс нь 23.7 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд 3.9 сая төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр худалдаж авсан, 0.6 сая төгрөгийн хөрөнгийг хандиваар авч нийт 4.6 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант хугацаанд байгуулсан 3.7 сая төгрөгийн элэгдлийн зардлаар буурч 24.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Цэвэр хөрөнгө өмчийн дүн буурсан нь хуримтлагдсан үр дүнгийн үлдэгдэл тайлант үеийн үр дүн 0.1 сая төгрөгийн буурсантай холбоотой байна.

**Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт** /сая.төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	94.3	81.4	-12.9
Нэмэлт санхүүжилтийн орлого		0.6	0.6
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		5.4	5.4
Үйл ажиллагааны орлого	94.3	87.4	-6.9
Бараа үйлчилгээний зардал	69.8	83.2	13.4
Урсгал шилжүүлэг	29.3	4.3	-25.0
Үйл ажиллагааны зардал	99.1	87.5	-11.6
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-4.8	-0.1	4.7

Цэнхэр сумын ИТХ-ын санхүүгийн үр дүнгийн тайлангийн урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого өмнөх оноос 12.9 сая төгрөг буюу 13.6 хувиар буурсан нь тэтгэвэрт гарахад олгодог санхүүжилттэй холбоотой бөгөөд төлөвлөсөн санхүүжилтийг зарцуулж ажилласан байна.

**3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 90.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 8.7 сая төгрөгөөр бууруулж нийт зардлыг 81.3 сая төгрөгөөр хянаж баталжээ.

**3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 81.3 сая төгрөгийн төсөв батлагджээ. Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 81.3 сая төгрөгийн санхүүжилт авч 77.1 сая төгрөгийг урсгал үйл ажиллагаандаа зарцуулж 4.2 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Төвлөрүүлэх шилжүүлэг нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 4.2 сая төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав

**3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 5.4 сая төгрөг Аймгийн ИТХ-ын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд зориулан зарцуулахаар ирсэн байна. Анхан шатны баримтаас тулган шалгахад 0.5 сая төгрөг цахим хурлын нэгжийн зардалд, 4.8 сая төгрөгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх урамшуулалт эргүүлийн зардалд зарцуулсан байна.

*Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.*

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Цэнхэр сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга С.Бадамханд нь 2020 оны 12 дугаар сард өндөр насны тэтгэвэр тогтоох эрх үүсэж, тэтгэмжээ авсан байхад 2021 онд урьд авч байсан цалин нэмэгдлүүдийг хэвээр тооцож олгосон нь Төрийн албаны тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжтой нийцэхгүй байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 6 үндсэн зорилтын хүрээнд 40 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээг 100.0 хувь хэрэгжүүлсэн байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан нийт 81.3 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 77.1 сая төгрөгийг зарцуулж, 94.8 хувийн биелэлттэй.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

1. Төсвийн хэмнэлтийн талаар авсан арга хэмжээ, түүний үр дүн судалгааг авч үзэхэд Цэнхэр сумын ИТХ нь 3.9 сая төгрөгөөр тавилга, эд хогшил бэлтгэсэн ЗГ-ын 43-р тогтоолын 1.4 дэх заалтыг зөрчсөн байна.
2. Тус байгууллага нь өөрийн эзэмшлийн Land-100 автомашинтай бөгөөд шатахууны зардалд 0.3 сая төгрөг, сэлбэг хэрэгслийн зардалд 2.9 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Харин бусад судалгаанд хамаарах мэдээлэлгүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан /Local.audit.mn сайтад шивсэн/, Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай ЗГ-ын 43-р тогтоолын хэрэгжилтийг судалгаагаар шалгаж баримтжууллаа.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Цэнхэр сумын ИТХ нь тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 144 мэдээллээс 131 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна. Харин 13 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “4.1.3.тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг хүргүүллээ.

### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тайлант онд батлагдсан төсвийн 26.4 хувь буюу 4.2 сая төгрөгийн хэмнэлт бий болгож төсөвт буцаан төвлөрүүлсэн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1 дэх заалттай нийцэж байна.

3.9.2.1 “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 43 дугаар тогтоолтой нийцүүлэн үзэхэд Цэнхэр сумын ИТХ нь 3.9 сая төгрөгөөр тавилга, эд хогшил бэлтгэж тус тогтоолын 1.4 дэх заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Зөрчлийг таслан зогсоож Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүллээ.

3.9.2.2 ИТХ-ын нарийн бичгийн дарга нь ажлаас чөлөөлөгдөж, өндөр насны тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн байхад сул орон тоонд сонгон шалгаруулалт явуулж нөхөн томилгоо хийх хүсэлтийг Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлээгүй байна. Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 27.1, 27.2, 46.2.2, 46.3 заалтуудыг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** ИТХ-ын нарийн бичгийн даргын албан тушаалд сонгон шалгаруулалт явуулах саналыг Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлж, сул орон тоог нөхөж Төрийн тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд буюу Засгийн газрын 43-р тогтоолын хэрэгжилт, холбогдох шалгуурт бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### **3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Цэнхэр сумын ИТХ-д завсрын аудит хийгээгүй байна. Өмнөх жилийн санхүүгийн тайлангийн аудитаар дотоод хяналт, үндсэн хөрөнгийн элэгдлийн хугацаатай холбоотой зөвлөмж хүргүүлснийг хэрэгжүүлж биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 11-ний 12 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### **3.12 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Төрийн жинхэнэ албан хаагчийн сул оронд хуулийн дагуу сонгон шалгаруулалт явуулсан эсэхийг шалгах

#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 36.5 сая төгрөгийн 7 алдаа зөрчил илэрснээс аудитын явцад 0.8 сая төгрөгийг залруулж, 28.7 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 3.9 сая төгрөгийн зөрчилд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах 2 албан шаардлага, 3.0 сая төгрөгийн 3 зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

*Залруулагдаагүй 2 алдаа, зөрчлийн дүн 32.6 сая төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдлаас хэтэрсэн тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.*

##### 4.1 Залруулсан алдаа

Нярав эд хариуцагчийн тайланг анхан шатны баримтаас тулган шалгахад 0.3 сая төгрөгийн чанга яригч, 0.5 сая төгрөгийн мананцаржуулагчийг бүртгэлд тусгаагүй байна. Аудитын явцад дээрх хөрөнгийг холбогдох байгууллагуудын дансанд бүртгэлжүүлж залруулга хийлгэлээ.

##### 4.2 Төлбөрийн акт

ИТХ-ын нарийн бичгийн дарга С.Бадамханд нь өндөр насны тэтгэвэр тогтоолгоогүй байхад төрийн албан хаагчид тэтгэвэрт гарахад олгодог нэг удаагийн мөнгөн тэтгэмжээ 2020 оны 12 дугаар сард авсан боловч сул орон тоонд сонгон шалгаруулалт явуулж нөхөн томилгоогүй хийхгүйгээр 2021 онд үргэлжлүүлэн ажиллуулж цалин хөлсийг урьд авч байсан хэмжээгээр тооцож олгосон нь Төрийн албаны тухай хуулийн 27.1, 27.2, 46.2.2, 46.3 дахь заалт, "Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам"-ын 1.1, 5.3 дахь заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төрийн албанд ажилласан 36 сарын тэтгэмжийг хөдөлмөрийн харилцаа дуусгавар болох хүртэл нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлэх, төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэлээ.

##### 4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

###### **Зардлын данстай холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Бараа үйлчилгээний болон бусдаар гүйцэтгүүлсэн ажлын төлбөр хураамжийн данснаас 3.0 сая төгрөгийн ажил гүйлгээг шилжүүлэхдээ цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч е-баримтаар баталгаажсан ажил гүйлгээг гаргаж хэвших зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

###### **Анхан шатны баримтын бүрдүүлэлттэй холбоотой асуудал**

ИТХ-ын дарга С.Ууганбатад анхан шатны нотлох баримтын бүрдүүлэлт дутуу байхад ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй үндэслэлээр 1.5 сарын цалинг нөхөн олгосон байна.

**Шийдвэрлэсэн нь:** Нэмэгдэл хөлс тооцон олгохдоо ЗГ-ын 2019 оны 382-р тогтоолын 2 дугаар хавсралт "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдад нэмэгдэл хөлс олгох журам"-ын холбогдох маягтыг бүрдүүлэн ажиллах зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 6 дугаар сарын 01 -ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Цэнхэр сумын ИТХ	5	36.5	1	0.8	1	28.7	1	4.0	2	3.0
Санхүүгийн тайлангийн аудитын шалгасан нийцлийн аудитын асуудал											
2	Цэнхэр сумын ИТХ	2						1		1	
<b>НИЙТ ДҮН</b>		<b>7</b>	<b>36.5</b>	<b>1</b>	<b>0.8</b>	<b>1</b>	<b>28.7</b>	<b>2</b>	<b>4.0</b>	<b>3</b>	<b>3.0</b>